

## **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Г.ЗАНДАНШАТАРЫН БАЯР ХҮРГЭЖ ХЭЛСЭН ҮГ**

Монгол, Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүд үргэлжилж, түүний хүрээнд өнөөдөр зохиогдож байгаа энэхүү олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчид та бүхний амрыг эрж, энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Юуны өмнө хурал зохион байгуулагчид болон хуралд оролцогчид Та бүхэнд Гадаад харилцааны сайдын зөвлөлийн өмнөөс Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 90 жилийн ойн босгон дээр манай хоёр улсын харилцааны түүхийг орчин үетэй нь холбон авч үзэж хэлэлцэх боломж олгосон чухал арга хэмжээ зохион байгуулж байгаад талархал илэрхийлж, баяр хүргэе.

Монгол Улсын 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнолыг батжуулахад 1921 оны Ардын хувьсгал чухал үүрэг гүйцэтгэж Монгол Улсыг түүхийн шинэ үйл явцад төр улсаа байгуулан, олон улсын харилцааны субъект болох нөхцлийг бүрдүүлсэн юм.

Монгол орны газар зүйн онцлог байршлын улмаас их гүрнүүдийн манайхыг тойрсон улс төр-стратегийн ашиг сонирхлын өрсөлдөөн идэвхжсэн түүхэн ээдрээтэй нөхцөлд Ардын засгийн газар өөрийн орны туурга тусгаар байдлыг бэхжүүлэх, улс төр, нийгмийн шинэ тогтолцооны үндсийг тавьж, ахиулахад чиглэсэн бодлого, идэвхтэй үйл ажиллагааг явуулж байсны нэг нь “үндэсний тусгаар тогтнолоо сэргээх зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө Зөвлөлт Орос Улстай нөхөрлөх нь чухал” гэсэн шийдвэр байжээ.

Энэ шийдвэрийн дагуу Монгол Улс 1921 оны 10 дугаар сард Зөвлөлт Орос Улсад төлөөлөгчөө явуулан хэлэлцээ хийж 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр, тухайн үеийн монголын цаг тооллоор олноо өргөгдсөний 11 оны намрын адаг сар буюу 10 дахь сарын шинийн 6-ны өдөр “Монгол, Оросын хооронд найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн Газар ба Зөвлөлийн Засагт Орос Улсын Засгийн Газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг” буюу бидний одоогийн томъёоллоор бол “Монгол Улс, Орос Улсын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан юм.

Монгол Улсаас гадаад улстай эрх тэгш зарчимд тулгуурлан байгуулсан анхны энэхүү хэлэлцээр нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн эгзэгтэй үеийн эрх зүйн чухал суурь баримт бичиг болсон бөгөөд түүгээр бүрэн эрхт дипломат болон консулын төлөөлөгчөө харилцан солилцохоор тохирч, дипломат харилцаа тогтоосон нь хоёр улс бие биеийнхээ бүрэн эрхт байдлыг хүлээн

зөвшөөрсөн хэрэг гэж олонхи судлаачид үздэг нь эрх зүйн бүрэн үндэслэлтэй дүгнэлт юм.

Хэлэлцээрийн дагуу хоёр улс дипломат харилцаа тогтоож, 1922 онд Улаанбаатар хот болон Москва хотод Элчин сайдын яамаа харилцан нээсэн нь шинэ Монгол Улсыг гадаад улс хүлээн зөвшөөрсөн анхны үйл хэрэг байсан бөгөөд цаашид Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулах үндэс суурийг тавьснаараа түүхэн их ач холбогдолтой үйл явдал болжээ.

Монгол Улсын Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон цаашдын харилцаа, нягт хамтын ажиллагаа нь 1939 онд Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, 1945 онд Монгол Улсын бүрэн эрхт байдлыг дэлхийн нөлөө бүхий томоохон улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх, 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болоход чухал ач холбогдолтой болсон билээ.

Хоёр улсад тогтсон нийгмийн шинэ тогтолцооны эхэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 онд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” нь манай хоёр орны орчин цагийн харилцааны эрх зүйн үндэс болж байна.

1994 онд баталж, 2011 онд шинэчилсэн Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ” гэж заасан. Энэхүү заалт үндсэндээ амжилттай хэрэгжиж ирсэн бөгөөд тэнцвэртэй харилцана гэдэг нь бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, итгэлцэл, ойлголцлыг бэхжүүлэх үндсэн дээр сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх салбарт идэвхтэй хөгжүүлэхийг хэлж байгаа билээ.

Эдүгээ Монгол, Оросын улс төрийн харилцаа идэвхтэй өрнөж, хамтын ажиллагааны бусад салбарын хөгжилд таатай нөхцлийг бүрдүүлж байна. Хоёр улсын хооронд дээд, өндөр түвшний харилцан айлчлал тогтмолжлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 онд ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үед хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх тухай тохиролцоонд хүрч, “Москвагийн тунхаглал” байгуулсан бол ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевийн 2009 онд Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын дүнд “Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай тунхаглал” гаргаснаар хоёр орны харилцаа цаашид урт хугацаанд тогтвортой урагшлан хөгжих хэтийн төлвийг нээж өгсөн юм.

Хоёр талын харилцааг нэгтгэн зохицуулах үүрэгтэй ГХЯ-дын хамтын ажиллагаа хэвийн явагдаж байна. ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров 2006 онд Монгол Улсад айлчлав. Монгол Улсын Гадаад хэргийн сайд 2007 онд, Гадаад харилцааны сайд 2009 онд ОХУ-д айлчилсан. Одоо Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 90 жилийн ойг угтсан арга хэмжээнүүдийн хүрээнд ОХУ-ын Гадаад хэргийн нэгдүгээр орлогч сайдын Монгол Улсад ирэх айлчлалд бэлтгэж байна. ГХЯ-дын улс төрийн газрын захирлын түвшний хоёр талын уламжлалт зөвлөлдөх уулзалт саяхан манайд амжилттай боллоо. Гадаад харилцааг эдийн засагжуулах бодлогын хүрээнд ОХУ-тай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх бодлого явуулж, салбарын яамд, агентлагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөгчдийн айлчлал, чуулга уулзалтын тоо олширч байна.

Энэ чиглэлээр хоёр улсын Засгийн газар хоорондын комисс идэвхтэй ажиллаж, хамтын ажиллагаа урагшилж байна. Энэ харилцааны дүнд ОХУ-ын зээл, тусламж, дэмжлэгтэйгээр “Атарын 3 дугаар аян”, монголын мал сүргийг эрүүлжүүлэх төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, байгалийн бэрхшээлийг хүндрэл багатай давсан болно. Худалдааг либеральчлах, хамтарсан үйлдвэрүүдийн технологийг боловсронгуй болгож үр ашгийг нь нэмэгдүүлэх, Монгол Улсын ашигт малтмалыг ашиглах, уул уурхайг ордыг эзэмших, дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллах талаар яриа хэлэлцээ үргэлжилж, тохирсон асуудлуудыг хэрэгжүүлэх ажил удаашралтай ч гэсэн явагдаж байна. Улс төрийн харилцаанаасаа хоцронгуй яваа эдийн засгийн харилцааг цаашид үр ашигтай хөгжүүлэх өргөн боломж байгаа бөгөөд энэ талаар аль аль талаасаа хүч анхаарал тавин ажиллах шаардлага байна.

Хоёр улсын соёл, боловсрол, шинжлэх ухаан, онцгой байдал, цэрэг, хүмүүнлэгийн харилцаа амжилттай хөгжиж, ОХУ-д тус улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцагчдын тоо жилээс жилд өсч байна. Мөн ОХУ-ын муж, субъектуудтай хөгжүүлж буй хамтын ажиллагаа хоёр талын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний бага хурал Монгол, Оросын харилцааны түүхийг орчин үетэй харьцуулан дүгнэж, харилцааны залгамж чанар, сайн бүхнийг өвлөн үргэлжлүүлэх, хоёр орны түүхэн уламжлалт сайн хөршийн найрсаг харилцааг стратегийн түншлэлийн хүрээнд амжилттай хөгжүүлэхэд чиглэсэн мэргэн санаа, зөв зөвлөмж хэлж тус нэмрээ өгнө гэж найдаж байна.

Бага хурлыг зохион байгуулагчид, оролцогчдод дахин талархал илэрхийлж, хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.